



БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан¹)

БНСУ БОЛОН АНУ-ЫН ДАВХАР ТАТВАРЫН ГЭРЭЭНИЙ ДАГУУ БНСУ-Д БҮРТГЭГДЭЭГҮЙ ПАТЕНТЫН ТЕХНОЛОГИЙН РОЯЛТИ ТӨЛБӨР НЬ ДОТООДООС ЭХ ҮҮСВЭРТЭЙ ОРЛОГОД ХАМААРНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2021дү59908²

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 09 дугаар сарын 18-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Сувон хотын давж заалдах шатны шүүхэд хэргийг буцааж шийдвэрлэжээ.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч нь хагас дамжуулагч төхөөрөмж үйлдвэрлэх, борлуулах үйл ажиллагаа эрхэлдэг Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх)-д бүртгэлтэй хуулийн этгээд болно. 2011 онд Америкийн Нэгдсэн Улсад бүртгэл (цаашид “АНУ” гэх)-тэй “... LLC” -ийн зүгээс “DRAM” хагас дамжуулагч төхөөрөмжийн патентын эрх зөрчсөн гэх маргаан үүсгэсний дагуу талууд 2013.12.23-ны өдөр эвлэрч, патентын лиценз ашиглах болон эвлэрлийн гэрээг 5 жилийн хугацаатай байгуулжээ. Уг гэрээгээр нэхэмжлэгч нь АНУ-д бүртгэлтэй 40 патентын эрх ашиглах, жил бүр 1.6 сая ам.долларын төлбөр төлөхөөр тохиролцжээ.

Нэхэмжлэгч нь 2014.01.29-ний өдөр дээрх төлбөрийг шилжүүлэхдээ БНСУ болон АНУ-ын давхар татварын гэрээний дагуу “патентын эрх ашигласны роялти төлбөр” (англ: *royalty tax*³, цаашид “роялти төлбөр” гэх) -т 310,189,220 воны татвар төлсөн байна. Нэхэмжлэгч нь 2015.06.09-ний өдөр зөвхөн АНУ-д бүртгэлтэй патент ашигласан тул уг орлогыг БНСУ-ын дотоод эх үүсвэртэй гэж үзэхгүй гэж марган, төлсөн татварыг буцаан авах хүсэлтийг гаргасан байна.

Хариуцагч нь 2019.02.15-ны өдөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (сол: 법인세법, цаашид “ААНОАТТХ” гэх)-ийн 93 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт⁴ заасныг үндэслэн хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан бөгөөд

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://casenote.kr/%EB%8C%80%EB%B2%95%EC%9B%90/2021%EB%91%9059908>, (Сүүлд үзсэн: 2026.03.31).

² БНСУ-ын нийт шүүгчдийн буюу их суудлын хуралдаанаар уг хэргийг хэлэлцэж шийдвэрлэжээ.

³ Ашигт малтмал, газрын тосны нөөц ашиглах болон барааны тэмдэг, зохиогчийн эрх, патентын эрхийг ашигласны орлогод ногдуулдаг татварыг хэлнэ. БНСУ-ын хувьд “royalty tax” гэх үгийг ашиглалтын орлогын татвар гэж хуульчилсан байх бөгөөд “роялти төлбөр” гэж орчуулав.

⁴ БНСУ-ын ААНОАТТХ (1988)-ийн 93 дугаар зүйлийн 8 дахь хэсэг “дотоодоос эх үүсвэртэй ашиглалтын орлого: Дараах дэд заалтуудын аль нэгэнд хамаарах эрх, хөрөнгө, эсхүл мэдээллийг (цаашид энэ заалтад “эрх” гэх) дотоодод ашиглах, эсхүл түүний төлбөрийг дотоодод төлөх тохиолдолд тухайн төлбөр болон эдгээр эрхийг шилжүүлснээс үүссэн орлого. Энэ тохиолдолд 93



нэхэмжлэгчийн гаргасан гомдлыг татварын маргаан шийдвэрлэх зөвлөл хэрэгсэхгүй болгосон шийдвэрлэснээр шүүхэд нэхэмжлэл гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Анхан шатны шүүхээс: Маргааны гол зүйл болж буй 40 патентын эрх нь БНСУ-д бүртгэлгүй болох нь тогтоогдсон байна. БНСУ болон АНУ-ын давхар татварын гэрээний 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “ашигласны төлбөр” гэдгийг тодорхойлохдоо (а)-д “... патент, загвар, ашигтай загвар, зураг, нууц процесс, нууц томьёо, барааны тэмдэг болон үүнтэй төстэй эд хөрөнгө, эрх, мэдлэг, туршлага, чадвар, ... ашиглалт буюу ашиглах эрхийн төлөө авсан бүх төрлийн төлбөр”-ийг ойлгоно гэж заасан. Тус гэрээний 6 дугаар зүйлд “Энэ гэрээгээр орлогын эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлно” гэж заагаад, 3 дахь хэсэгт “14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан эд хөрөнгийг ашиглах буюу ашигласны төлөө төлөгдөх төлбөр аль гэрээт улсад хэрэгжиж байгаа тохиолдолд зөвхөн тэр улсад эх үүсвэртэй орлого гэж үзнэ” гэж заажээ.

Патентын эрхийн нутаг дэвсгэрийн зарчмын дагуу патент эзэмшигчийн патентлагдсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, шилжүүлэх, түрээслэх, импортлох, үзүүлэх зэрэг эрх нь зөвхөн тухайн патент бүртгэгдсэн улсын нутаг дэвсгэрт хүчинтэй гэж үзэх тул дотоодод бүртгүүлээгүй патентын эрхээс олсон орлогыг дотоодоос эх үүсвэртэй орлого гэж үзэх боломжгүй.⁵ Иймд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, татварын буцаан олголтыг өгөхөөс татгалзсан шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс: Анхан шатны шүүхээс хууль ёсоор цуглуулж, шалгасан нотлох баримтуудыг нэгтгэн үзэхэд тогтоосон баримт болон хийсэн

дугаар зүйлийн 4 дэх заалтад заасан үйлдвэрлэл, худалдаа, шинжлэх ухааны зориулалттай техник, тоног төхөөрөмж зэргийг түрээслүүлснээс үүссэн орлогыг татварын гэрээгээр ашиглалтын орлого гэж ангилсан бол тухайн ашиглалтын төлбөрийг багтаана.

а. Шинжлэх ухаан, урлагийн бүтээл (кино хальс хамаарна)-ийн зохиогчийн эрх, патентын эрх, барааны тэмдгийн эрх, загвар, модель, зураг, нууц томьёо эсхүл процесс, радио-телевизийн нэвтрүүлгийн зориулалттай хальс болон бичлэг, түүнчлэн эдгээртэй төстэй хөрөнгө эсхүл эрх;
б. Үйлдвэрлэл, худалдаа, шинжлэх ухааны мэдлэг, туршлагатай холбоотой мэдээлэл буюу ноу-хау;
в. Ашигласан газрыг үндэслэн дотоодоос эх үүсвэртэй орлого эсэхийг тодорхойлдог татварын гэрээнд (цаашид энэ зүйлд “ашиглалтын газар суурьтай татварын гэрээ” гэх) ашиглалтын төлбөрийн тодорхойлолтод багтах бусад төстэй хөрөнгө эсхүл эрх [патентын эрх, ашигтай загварын эрх, барааны тэмдгийн эрх, загварын эрх зэрэг хэрэгжүүлэхэд бүртгэл шаардлагатай эрхүүд (цаашид энэ зүйлд “патентын эрх гэх” гэх) дотоодод бүртгэгдээгүй боловч түүнд агуулагдах үйлдвэрлэлийн арга, технологи, мэдээлэл зэрэг нь дотоодын үйлдвэрлэл, боловсруулалттай холбоотойгоор дотоодод бодитоор хэрэгжсэн эсхүл ашиглагдсан тохиолдлыг хэлнэ], <https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%B2%95%EC%9D%B8%EC%84%B8%EB%B2%95>.

⁵ Дээд шүүхийн 2014. 11. 27-ны өдрийн 2012 두 18356 шийдвэр (да법원 2014. 11. 27. 선고 2012 두 18356 판결), Дээд шүүхийн 2018. 12. 27-ны өдрийн 2016 두 42883 шийдвэр (да법원 2018. 12. 27. 선고 2016 두 42883 판결)-ээр “АНУ-ын хуулийн этгээд патентын эрхийг гадаадад бүртгүүлсэн боловч дотоодод бүртгүүлээгүй, тухайн патентын эрхийг ашиглаж олсон орлогыг дотоодоос эх үүсвэртэй орлого гэж үзэх боломжгүй гэж дүгнэжээ. Тус шийдвэрүүдийг бүрэн эхээр үзэх холбоос: <https://casenote.kr/%EB%8C%80%EB%B2%95%EC%9B%90/2012%EB%91%9018356>, <https://casenote.kr/%EB%8C%80%EB%B2%95%EC%9B%90/2016%EB%91%9042883>, (Сүүлд үзсэн: 2026.04.03).



дүгнэлт нь үндэслэлтэй гэж дүгнээд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж хариуцагчийн давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Дээд шүүхийн шүүгчдийн олонхын санал: Дээд шүүх өмнө нь патентын эрхийг нутаг дэвсгэрийн зарчмаар тайлбарлаж дотоодод бүртгэгдээгүй патентын эрхийг ашиглахад роялти төлбөр төлөхгүй гэж үзэж байсан. Гэхдээ давхар татварын гэрээнд “ашиглах” гэдэг ойлголтыг тусгайлан тодорхойлоогүй тул уг гэрээний 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг⁶ заасны дагуу БНСУ-ын хуулийн дагуу тайлбарлах шаардлагатай гэж үзжээ.

Давхар татварын гэрээний дагуу “ашигласан газар”-ыг тогтоохын тулд эхлээд “ашиглах” гэдэг ойлголтын утгыг тодорхой болгох шаардлагатай. Энд “**ашиглах**” гэдэг нь онцгой эрхийн шинжтэй патентын эрхийг өөрийг нь ашиглахыг хэлэхгүй, харин тухайн патентын эрхийн объект болох үйлдвэрлэлийн арга, технологи, мэдээлэл зэрэг (цаашид “патентын технологи” гэх)-ийг ашиглахыг хэлнэ гэж үзэх нь зүйтэй. “Ашиглах” гэдэг нь зөвхөн “патент”-д хамаарах ойлголт биш биет бус хөрөнгийн бүх төрөлд нийтлэг, цогц байдлаар хамаарах ойлголт юм. Биет бус хөрөнгийн бүх төрөлд нийтлэг “ашиглах” гэдэг нь бүртгэлээр дамжин онцгой эрхийн шинж олж авсан эрхийг өөрийг нь ашиглахыг хэлэхгүй, харин тухайн биет бус хөрөнгийн агуулгыг бүрдүүлж буй технологи, мэдээлэл зэргийг ашиглахыг хэлнэ. Патентын эрхийн нутаг дэвсгэрийн зарчмын хувьд патентын технологийг дотоодод ашиглах нь гадаадын патент эзэмшигчийн эрхийг дотоодод зөрчсөн үйлдэлд хамаарахгүй бөгөөд тухайн патентын технологи нь эдийн засгийн үнэ цэнтэй тул түүний улмаас үүссэн орлогод ногдох роялти төлбөрийг төлөх ёстой гэж дүгнэсэн байна.

Тусгай санал: Дээд шүүх нь патентын эрхийн нутаг дэвсгэрийн зарчмыг 1992 оноос 2022 он хүртэл БНСУ болон АНУ-ын давхар татварын гэрээний “патент ашиглах” гэх ойлголтод тулгуурлан, дотоодод бүртгэгдээгүй патентын эрхийг ашиглахыг импортлох, борлуулах зэрэг патентлагдсан бүтээлийг хэрэгжүүлэх гэсэн байр сууринаас тайлбарлаж ирсэн. Давхар татварын гэрээний үг хэллэг, агуулга, зорилгоос гадна хэлцэлд оролцогч талуудын хүсэл зоригийг нэгтгэн авч үзвэл, “дотоодод бүртгэгдээгүй патентын эрхийн роялти төлбөр”-ийг дотоодоос эх үүсвэртэй орлогод хамаарна гэж үзэх боломжгүй тул олонхын саналыг дэмжихгүй гэсэн тусгай санал гарчээ.

Эцэст нь анхан шатны шүүх уг роялти төлбөр нь дотоодод бүртгэгдээгүй патентын эрхтэй холбоотой гэсэн үндэслэлээр тухайн патентын технологи дотоодод үйлдвэрлэл, борлуулалт зэрэгт бодитоор ашиглагдсан эсэхийг шалгалгүйгээр шууд дотоодоос эх үүсвэртэй орлогод хамаарахгүй гэж буруу дүгнэсэн байна. Эрх зүйн үндэслэлийг буруу тайлбарласны улмаас шаардлагатай ажиллагааг бүрэн явуулаагүй, улмаар шийдвэрт нөлөөлсөн алдаа гаргасан гэж үзэн

⁶ БНСУ болон АНУ-ын давхарт татварын гэрээний 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг “гэрээнд тодорхойлоогүй нэр томъёо нь татвар тогтоогдож буй гэрээт улсын хуулийн дагуу утга агуулгатай байна гэж заасан хэдий ч, уг гэрээний агуулгын хүрээнд тухайн нэр томъёоны утгыг өөрөөр тайлбарлах шаардлагатай бол тухайн агуулгад нийцүүлэн тайлбарлана” гэж заажээ.



анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг Сувон хотын давж заалдах шатны шүүхэд буцаан шийдвэрлэжээ.⁷

БНСУ-ын хувьд дээд шүүхээс хэргийг буцааж шийдвэрлэсэн тохиолдолд дээд шүүхээс дүгнэлт өгч шийдвэрлэсэн хэсэг нь хүчин төгөлдөр болох бөгөөд давж заалдах шатны шүүхээс хэргийг буцаасан хэсгийн хүрээнд хянан шийдвэрлэнэ.⁸

---o0o---

⁷ БНСУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 436 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хэргийг буцаан шилжүүлсэн эсхүл шилжүүлэн авсан шүүх нь дахин шүүх хуралдаан явуулж, хэргийг шийдвэрлэх ёстой. Энэ тохиолдолд тухайн шүүх нь Дээд шүүхээс шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болгосон баримтын болон эрх зүйн дүгнэлтийг дагаж мөрдөнө гэж хуульчилсан байдаг.

⁸ 호문혁, 민사소송법 (제 15 판), 파주법문사(2024), 747. Ho Moon-hyuck, Minsasosongbeob (je15pan), Paju bobmunsa (2024), 769.